



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.Энэ хуулийн зорилт нь үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдох нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл.Зөвшөөрлийн хууль тогтоомж

1.Зөвшөөрлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

[/Энэ хэсэг т 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

1.3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

1.Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл /цаашид "зөвшөөрөл" гэх/-тэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.

2.Монгол Улсад зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна.

3.Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

4.Энэ хууль доор дурдсан харилцаанд үйлчлэхгүй:

4.1.Монгол Улсын иргэнд газар өмчлөх эрх олгох;

4.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд цагаачлан оршин суух зөвшөөрөл олгох, гадаадын иргэнд Монгол Улсын хилээр нэвтрэх эрх олгох буюу Монгол Улсын виз олгох, Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг олгох, олгосон виз, визийн зөвшөөрөл, зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

4.3.хурал, цуглаан, жагсаал, нийтийг хамарсан бусад арга хэмжээ зохион байгуулах;

4.4.патент, зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн болон газар зүйн заалт, барааны тэмдэг эзэмшигчийн эрх олгох;

4.5.Монгол Улсад олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

4.6.сүм, хийд буюу шашны байгууллага байгуулах;

4.7.холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох;

4.8.хуульд Монгол Улсын Их Хурлаас олгохоор заасан зөвшөөрөл.

4.9.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох.

[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.Хүн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр төрийн байгууллага, албан тушаалтан, бусад эрх бүхий этгээдээс дүгнэлт, батламж, тодорхойлолт гаргуулах харилцаанд энэ хууль хамаарахгүй.

6.Энэ хуульд заасан зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаа нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн

1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 1.1. "зөвшөөрөл" гэж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрхийг;
- 1.2. "зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд" /цаашид "эрх бүхий этгээд" гэх/ гэж хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан төрийн байгууллага, албан тушаалтан, эсхүл төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдийг;
- 1.3. "зөвшөөрөл эзэмшигч" гэж тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахаар эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авсан этгээдийг.

1.5 дугаар зүйл. Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээ

1. Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй холбогдох бусад харилцаанд доор дурдсан зарчмыг баримтална:

- 1.1. үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашиг, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах;
- 1.2. хууль дээдлэх;
- 1.3. ил тод, шударга байх;
- 1.4. бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;
- 1.5. хуульд зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардахгүй байх;
- 1.6. энэ хуульд заасан зөвшөөрөл олгох.

2. Зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх хуульд заасны дагуу тухайн зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ.

3. Хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно.

4. Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бөгөөд үүсэх үр дагаврыг зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон, эрх шилжүүлсэн этгээд хариуцна.

5. Засгийн газар үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, нийтийн ашиг сонирхол, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдээс олгодог зөвшөөрлийг олгох үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийж болно.

6. Хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын тогтоосон хувь, хэмжээнд багтаан эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгоно.

7. Хуульд өөрөөр заагаагүй бол нэг зөвшөөрлийг нэг хүн, эсхүл нэг хуулийн этгээдийн нэр дээр олгоно.

8. Хуульд заасан тохиолдолд тухайн зөвшөөрлийг хуулийн этгээдэд, эсхүл тодорхой төрөл, хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээдэд, эсхүл хувь хүнд, эсхүл Монгол Улсын иргэнд олгоно.

9. Хуульд заасан тохиолдолд зарим төрлийн зөвшөөрлийг зөвшөөрөл эзэмшигчид олгоно.

10. Хуульд заасан тохиолдолд тодорхой төрлийн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулж болно.

11. Эрх бүхий этгээд уялдаа холбоо бүхий зарим төрлийн зөвшөөрлийн олгох, сунгах үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж болно.

12. Зөвшөөрөл эзэмшиж байгаатай нь холбогдуулан зөвшөөрөл эзэмшигчийн тодорхой эрхийн хязгаарлалтыг хуулиар тогтооно.

13. Хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааны чиглэлийг тодотгосон үг, тэмдэглэгээ хэрэглэх бөгөөд тухайн үг, тэмдэглэгээг тухайн үйл ажиллагааг эрхэлж байгаа, эсхүл уг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан гэсэн сэтгэгдэл төрүүлэхүйц байдлаар бусад этгээд ашиглах, хэрэглэхийг хориглоно.

14. Зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзана.

15. Энэ зүйлийн 14-т заасан судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын баталсан аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

16. Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглоно.

17. Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг

хориглоно.

18.Байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулах зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

19.Хуульд зааснаас бусад тохиолдолд энэ зүйлийн 18-д зааснаас бусад зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРӨЛ

2.1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн ангилал

1.Зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан доор дурдсанаар ангилна:

1.1.тусгай зөвшөөрөл;

1.2.энгийн зөвшөөрөл.

2.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад тусгай зөвшөөрөл олгоно.

3.Нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагаа, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ахуйн хэрэгцээний зориулалтаар ашиглуулахад энгийн зөвшөөрөл олгоно.

4.Тусгай зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг бүрэн хангуулах үүднээс урьдчилсан байдлаар олгож болно.

2.2 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацаа

1.Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг таван жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно.

2.Байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон зөвшөөрлийг хугацаатай олгоно.

3.Энэ зүйлийн 2-т зааснаас бусад зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно.

4.Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагааны хугацаа нь тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна.

2.3 дугаар зүйл.Зөвшөөрлийн код

1.Зөвшөөрлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, статистик мэдээг эрхлэн гаргах, лавлагаа өгөх, цахим хэлбэрээр зөвшөөрөл олгох зорилгоор зөвшөөрлийг кодолно.

2.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрлийн кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалт болон үндэсний кодыг харгалзан тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД, ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

3.1 дүгээр зүйл.Эрх бүхий этгээд

1.Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох бөгөөд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвшөөрөл олгох бүрэн эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.2 дугаар зүйл.Эрх бүхий этгээдийн бүрэн эрх

1.Эрх бүхий этгээд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах;

1.2.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

1.3.тухайн зөвшөөрлийн нөхцөл, шаардлагатай холбогдох мэдээ, тайланг зөвшөөрөл эзэмшигчээс авах.

2.Эрх бүхий этгээд дараах үүрэг хүлээнэ:

2.1.хуульд заасан зарчмыг баримтлах;

- 2.2.хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох;
- 2.3.зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах;
- 2.4.зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргах;
- 2.5.энэ зүйлийн 2.4-т заасан шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухайн шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор бүртгүүлэх;
- 2.6.зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах, тухайн шийдвэрийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх;
- 2.7.зах зээлд чөлөөтэй өрсөлдөхөд ялгамжтай хандахгүй байх, түүнчлэн өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор хуульд зааснаас бусад үндэслэлээр зөвшөөрлийг олгохоос татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээг авахгүй байх;
- 2.8.зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;
- 2.9.зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргах баримт бичгийн жагсаалт болон өргөдөл хүлээн авах этгээд, түүний хаяг, байршлын талаарх мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх.

3.3 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох эрх шилжүүлэх

1.Хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.7-д заасан хуулийн этгээдэд шилжүүлж болно.

[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

- 2.Эрх шилжүүлэн авсан этгээд энэ хуулийн 3.2 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж, үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.Энэ зүйлийн 1-д заасан эрх шилжүүлэх журмыг Засгийн газар батална.
- 4.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ бусдад шилжүүлсэн бол шийдвэрийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, энэ тухай нийтэд мэдээлнэ.
- 5.Зөвшөөрөл олгох эрхийг хууль бусаар шилжүүлсний улмаас бусдад учирсан хохирлыг тухайн эрх шилжүүлсэн этгээд хариуцна.

3.4 дүгээр зүйл.Зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах

- 1.Хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд нь зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай шаардлага, нөхцөлийг хэрэгжүүлэх зорилгоор зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж болно.
- 2.Гэрээний нөхцөл, шаардлага, гэрээ байгуулахтай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ, ЭЗЭМШИГЧИД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА, ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 дүгээр зүйл.Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага

- 1.Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн үйл ажиллагааг эрхлэх этгээд дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:
 - 1.1.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;
 - 1.2.хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх;
 - 1.3.татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх.

4.2 дугаар зүйл.Зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

- 1.Зөвшөөрөл эзэмшигч дараах эрхийг эдэлнэ:
 - 1.1.зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг эрхлэх;
 - 1.2.зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргах;
 - 1.3.зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон мэдээлэл, лавлагааг авах;
 - 1.4.хуульд заасны дагуу зөвшөөрлийг бусдад шилжүүлэх;
 - 1.5.зөвшөөрлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан тухайн зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл бүрэн бус, алдаатай, буруу бол залруулах талаар эрх бүхий этгээдэд хүсэлт гаргах;
 - 1.6.эрх бүхий этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, шийдвэрийн талаар холбогдох хуульд заасны дагуу гомдол гаргах;

1.7.хуульд заасан бусад.

2.Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

2.1.хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх;

2.2.тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах;

2.3.хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

2.4.хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэн явуулах;

2.5.зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх;

2.6.санхүүгийн үйлчилгээний зөвшөөрөл эзэмшигч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2.7.үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөх;

[/Энэ заалт ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.8.зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчийг ялгаварлахгүйгээр тухайн үйлчилгээгээр шуурхай хангах;

2.9.хуульд заасан бусад.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ ЖУРАМ

5.1 дүгээр зүйл.Зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах

1.Зөвшөөрөл хүсэгч зөвшөөрөл хүссэн өргөдлийг түүнд хавсаргах баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд гаргана.

2.Зөвшөөрөл хүссэн өргөдөл нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг шаардлагыг хангасан байна.

3.Зөвшөөрөл хүсэгч өргөдөлд зөвшөөрлийн ангилал, түүнд холбогдох үйл ажиллагааны болон байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглах зорилго, үндэслэлийг тодорхой тусгах бөгөөд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

3.1.зөвшөөрөлд тавигдах хуульд заасан нийтлэг нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг;

~~3.2.хуульд заасан бол улсын тэмдэгийн хураамж төлсөн баримт;~~

[/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

3.3.хуульд тусгайлан заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг.

4.Эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт зөвшөөрөл хүссэн өргөдөлд тусгай зөвшөөрлийг авахад бүрдүүлсэн баримт бичиг буюу энэ зүйлийн 3.1, 3.3-т заасан баримт бичгийг дахин шаардахгүй.

5.Цахим хэлбэрээр гаргасан зөвшөөрөл хүссэн өргөдлийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасны дагуу бичгээр гаргасан хүсэлт гэж үзнэ.

5.2 дугаар зүйл.Зөвшөөрөл хүссэн өргөдөл шийдвэрлэх журам

1.Эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд өргөдлийг хүлээн авсан тухай зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэж, энэ тухай бүртгэлд тусгана.

2.Эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, дараах арга хэмжээ авна:

2.1.баримт бичгийн бүрдэл хангасан гэж үзвэл магадлан шалгах ажиллагааг эхлүүлэх;

2.2.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол нөхөн бүрдүүлэх талаар зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэх;

2.3.өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэх.

3.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 2-т заасан арга хэмжээний талаар зөвшөөрөл хүсэгчид баримт бичгийн бүрдлийг шалгах хугацаанд багтаан мэдэгдэнэ. Нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг тус бүрийн талаар мэдэгдэлд тодорхой тусгана.

4.Энэ зүйлийн 2.2-т заасан баримт бичгийг нөхөн бүрдүүлэх хугацаа 30 хүртэл хоног байна. Энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол өргөдөл гаргаагүйд тооцно.

5.Зөвшөөрөл хүсэгч хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг эрх бүхий этгээд дараах хугацаанд магадлан шалгана:

5.1.тусгай зөвшөөрлийг ажлын 10 өдрийн дотор;

5.2.энгийн зөвшөөрлийг ажлын таван өдрийн дотор.

- 6.Эрх бүхий этгээд магадлан шалгах ажиллагаанд шаардлагатай нэмэлт мэдээлэл, лавлагаа, дүгнэлт, тодорхойлолт зэргийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.13-т заасны дагуу холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авна.
- 7.Магадлан шалгах ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагаас дүгнэлт, тодорхойлолт гаргуулах шаардлагатай бол энэ зүйлийн 5-д заасан хугацааг нэг удаа ажлын таван өдрөөр сунгаж болно.
- 8.Эрх бүхий этгээд магадлан шалгах ажиллагааг дууссанаас хойш ажлын таван өдөрт багтаан зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана.
- 9.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоос татгалзсан бол мэдэгдэлд татгалзсан үндэслэлийг тодорхой заана.
- 10.Энэ зүйлийн 9-д заасан мэдэгдлийг мэдэгдэл гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор зөвшөөрөл хүсэгчид бичгээр хүргүүлнэ.
- 11.Эрх бүхий этгээд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тухайн зөвшөөрөл хүсэгчээс зургаан сарын дотор уг чиглэлээр хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.
- 12.Хуульд заасан хугацаанд хариу өгөөгүй нь холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.

5.3 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргах

- 1.Эрх бүхий этгээд энэ хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргана.
- 2.Энэ зүйлийн 1-д заасан шийдвэр болон улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ, төлөх хугацааны талаар тухайн шийдвэр гарсан өдөрт багтаан зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэнэ.
[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)
- 3.Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий байгууллагын шийдвэр, эсхүл зөвшөөрөлд дараах мэдээллийг тусгана:
 - 3.1.эрх бүхий этгээдийн нэр;
 - 3.2.эрх бүхий этгээдийн шийдвэрийн нэр, он, сар, өдөр;
 - 3.3.зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг;
 - 3.4.зөвшөөрлийн ангилал, эрхлэх үйл ажиллагааны нэр;
 - 3.5.зөвшөөрлийн хугацаа;
 - 3.6.зөвшөөрлийн дугаар, олгосон он, сар, өдөр;
 - 3.7.эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга /тэмдэг/.
- 4.Хуульд заасан тохиолдолд энэ зүйлийн 3-т зааснаас бусад мэдээллийг эрх бүхий байгууллагын шийдвэр, эсхүл зөвшөөрөлд тусгаж болно.
- 5.Эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд энгийн зөвшөөрөл хүссэн өргөдлийн хариуг өгөөгүй бол зөвшөөрөл олгосонд тооцно.
- 6.Энэ зүйлийн 5-д заасны дагуу олгосонд тооцох шийдвэрийг эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэх хугацаа дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор гаргана.
- 7.Энэ зүйлийн 6-д заасан шийдвэр болон улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ, төлөх хугацааны талаар тухайн шийдвэр гарсан өдөрт багтаан зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэнэ.
[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)
- 8.Эрх бүхий этгээд шийдвэр гаргасан өдрөөс хойш тав хоногийн дотор зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр энэ хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу зөвшөөрлийн баримт бичгийг олгоно.
- 9.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1, 6-д заасан шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухайн шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор бүртгүүлнэ.

5.4 дүгээр зүйл.Зөвшөөрлийн баримт бичиг

- 1.Эрх бүхий этгээд зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр, эсхүл хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгосныг баталгаажуулан зөвшөөрлийн баримт бичиг буюу гэрчилгээ, түүнтэй адилтгах эрхийн бичиг, бусад үнэт цаас бүхий баримт бичиг олгоно.
- 2.Зөвшөөрлийн баримт бичиг нь зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд зөвшөөрөл олгосон шийдвэр, зөвшөөрлийн лавлагааны нэгэн адил эрх зүйн хүчинтэй байна.
- 3.Зөвшөөрлийн баримт бичгийг гээх, үрэгдүүлэх, гэмтээх, хүлээж аваагүй байх нь зөвшөөрлийг хүчингүй гэж үзэх үндэслэл болохгүй.

5.5 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацааг сунгах

- 1.Эрх бүхий этгээд зөвшөөрлийн хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө түүнийг сунгуулах тухай мэдэгдлийг зөвшөөрөл эзэмшигчид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу мэдэгдэж, энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.
- 2.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл, хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд гаргана.

3.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 2-т заасан өргөдлийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд өргөдлийг хүлээн авсан тухай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.

4.Эрх бүхий этгээд зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, дараах арга хэмжээ авна:

4.1.баримт бичгийн бүрдэл хангасан гэж үзвэл магадлан шалгах ажиллагааг эхлүүлэх;

4.2.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол нөхөн бүрдүүлэх талаар зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэх.

5.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 4.2-т заасан арга хэмжээний талаар зөвшөөрөл эзэмшигчид баримт бичгийн бүрдлийг шалгах хугацаанд багтаан мэдэгдэнэ. Нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг тус бүрийн талаар мэдэгдэлд тодорхой тусгана.

6.Энэ зүйлийн 4.2-т заасан баримт бичгийг нөхөн бүрдүүлэх хугацаа 10 хоног байна. Энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол зөвшөөрлийг сунгуулах тухай өргөдөл гаргаагүйд тооцно.

7.Зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг эрх бүхий этгээд дараах хугацаанд магадлан шалгана:

7.1.тусгай зөвшөөрлийг ажлын таван өдрийн дотор;

7.2.энгийн зөвшөөрлийг ажлын гурван өдрийн дотор.

8.Эрх бүхий этгээд магадлан шалгах ажиллагаанд шаардлагатай нэмэлт мэдээлэл, лавлагаа, дүгнэлт, тодорхойлолт зэргийг энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 6-д заасны дагуу гаргуулан авна.

9.Магадлан шалгах ажиллагаанд төрийн болон мэргэжлийн байгууллагаас дүгнэлт, тодорхойлолт гаргуулах шаардлагатай гэж үзсэн бол энэ зүйлийн 7-д заасан хугацааг нэг удаа ажлын гурван өдрөөр сунгаж болно.

10.Эрх бүхий этгээд магадлан шалгах ажиллагааг дууссанаас хойш ажлын хоёр өдөрт багтаан зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх шийдвэрийг гаргана.

11.Эрх бүхий этгээд хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд зөвшөөрлийн хугацааг сунгахгаас татгалзана.

12.Энэ зүйлийн 11-д заасны дагуу татгалзсан бол үндэслэл бүхий шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор зөвшөөрөл эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

13.Хуульд заасан хугацаанд хариу өгөөгүй нь холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.

14.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл гаргасан, холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа бол эрх бүхий этгээд тухайн зөвшөөрлийн хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.

15.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч энэ зүйлийн 2-т заасан нөхцөл, шаардлагаас гадна татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй, байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалсан бол зөвшөөрлийн анх олгосон хугацааг хоёр дахин нэмэгдүүлж сунгаж болно.

[Энэ хэсэгт "татварын өргүй" гэснийг "татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй" гэж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

16.Эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийн хариуг өгөөгүй бол зөвшөөрлийн анх олгосон хугацаагаар сунгасанд тооцно.

17.Энэ зүйлийн 16-д заасны дагуу зөвшөөрлийг сунгасанд тооцсон шийдвэрийг эрх бүхий этгээд зөвшөөрлийг сунгуулах тухай өргөдлийг шийдвэрлэх хугацаа дууссанаас хойш ажлын хоёр өдрийн дотор гаргана.

18.Энэ зүйлийн 17-д заасан шийдвэрийг тухайн шийдвэр гарсан өдөрт багтаан зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

19.Эрх бүхий этгээд шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор зөвшөөрлийн баримт бичигт дараах тэмдэглэлийг хийнэ:

19.1.зөвшөөрлийн сунгасан хугацаа;

19.2.зөвшөөрлийн дугаар, сунгасан он, сар, өдөр;

19.3.зөвшөөрөл сунгасан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга /тэмдэг/.

20.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 14, 15, 17-д заасан шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухайн шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор бүртгүүлнэ.

5.6 дугаар зүйл.Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт

1.Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.8, 1.15, 1.23, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 6 дахь хэсгийн 6.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.18 дахь заалт, 5 дахь хэсгийн 5.1 дэх заалт, 8 дахь хэсгийн 8.14, 8.28, 8.29 дэх заалт, 9 дэх хэсгийн 9.2, 9.6, 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.11 дэх заалт, 11 дэх хэсгийн 11.1, 11.9, 11.12 дахь заалт, 12 дахь хэсгийн 12.1, 12.2, 12.14 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

[Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Энэ зүйлийн 1-д заасан журмаар зөвшөөрлийг олгох харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

6.1 дүгээр зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

1.Эрх бүхий этгээд дараах тохиолдолд зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

- 1.1.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
- 1.2.хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл буруу гаргасан;
- 1.3.зөвшөөрөл олгосноос хойш хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.

2.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1-д заасан үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.

3.Энэ зүйлийн 2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

4.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд ажлын хоёр өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

5.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1-д заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зөвшөөрлийг сэргээнэ.

6.2 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох

1.Зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

- 1.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
- 1.2.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;
- 1.3.зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
- 1.4.зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;
- 1.5.зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан болон бусад хэлбэрээр шилжүүлсэн;
- 1.6.зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 1.7.зөвшөөрөл эзэмшигч иргэн бол иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээд бол дампуурсан, эсхүл татан буугдсан;
- 1.8.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д заасан хугацаанд улсын тэмдэгтийн хураамжийг төлөөгүй.

[/Энэ заал т-ыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

1.9.хуульд заасан бусад.

[/Энэ заал т-ын дугаар т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

6.3 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох журам

1.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.

2.Энэ зүйлийн 1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч 30 хоногийн дотор зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол уг хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

3.Зөвшөөрөл эзэмшигч энэ зүйлийн 2-т заасан хугацаанд тайлбар өгөөгүй, энэ зүйлийн 1-д заасан мэдэгдэлд гомдол гаргаагүй бол зөвшөөрөл хүчингүй болгох үндэслэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

4.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд ажлын хоёр өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

6.4 дүгээр зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосны үр дагавар

1.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай холбогдох гэрээний үйлчлэлийг түр зогсоож болно.

2.Зөвшөөрлийг хүчингүй болгосон нь тухайн зөвшөөрөл эзэмшигчээс зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай холбогдуулан бусадтай байгуулсан гэрээг цуцлах үндэслэл болно.

3.Зөвшөөрлийг хүчингүй болгосны улмаас бусдад учруулсан хохирлыг зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нөхөн төлнө.

4.Зөвшөөрлийг хууль бусаар олгосны улмаас бусдад учирсан хохирлыг тухайн зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан эрх бүхий этгээд болон тухайн асуудал хариуцсан албан тушаалтан, эсхүл эрх шилжүүлэн авсан этгээд нөхөн төлнө.

5.Төрийн албан тушаалтан зөвшөөрөл олгох журмыг зөрчсөн, эсхүл үүрэгт ажилдаа илтэд болгоомжгүй хандсан, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл үүсч болох хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг арилгана.

6.Эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн зөвшөөрөл эзэмшиж байсан этгээдээс зургаан сарын дотор тухайн зөвшөөрлийг дахин хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

7.1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

1.Энэ хуульд заасан зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна.

[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.Энэ зүйлийн 1-д заасан зөвшөөрлийн нэгдсэн санг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

3.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1-д заасан явцын мэдээлэл, шийдвэрийг энэ хуульд заасан журмын дагуу зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

4.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 3-т заасан явцын мэдээлэл, шийдвэрийг зөвшөөрлийн нэгдсэн санд байршуулж, нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.

[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.

6.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1-д заасан явцын мэдээлэл, шийдвэрийн сан үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах үүрэгтэй.

[/Энэ хэсэг т 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

7.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.3-т заасан асуудлыг мэдээлэл технологийн дэвшилтэт аргыг ашиглан хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.2 дугаар зүйл.Зөвшөөрлийн лавлагаа, мэдээлэл

1.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой хүсэлт гаргасан этгээд, түүний бүрдүүлсэн баримт бичиг болон зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт тавих эрх бүхий этгээдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нээлттэй, ил тод байна.

2.Зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой мэдээлэл хуульд заасны дагуу тухайн этгээдийн нууцад хамаарахаар бол түүнтэй холбоотой лавлагааг зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн үндсэн дээр олгоно.

3.Энэ зүйлийн 2-т заасан лавлагааг ажлын таван өдрийн дотор, бусад лавлагааг ажлын гурван өдрийн дотор олгоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРЛӨӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийн жагсаалт

1.Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| | |
|------------------|---|
| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|------------------|---|

| | |
|---|---|
| 1.1.нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах | Засгийн газар |
| 1.2.амьтныг сэргээн нутагшуулах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.3.амьтан тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.4.ан, амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.5.аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.6.байгаль орчны аудит хийх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.7.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.8.генетикийн нөөц, генетикийн нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.9.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.10.озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин боловсруулах, дахин цэнэглэх, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засвар үйлчилгээ хийх, устгах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.11.ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх | Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 1.12.усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.13.харь амьтныг нутагшуулах, өсгөж үржүүлэх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.14.химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.15.ховор амьд амьтны цуглуулга хийх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.16.ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.17.хувиргасан амьд организмыг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.18.тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах | Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.19.ургамлыг гадаад улсад гаргах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага |

| | |
|--|---|
| 1.20.олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох | Удирдан зохицуулах зөвлөл |
| 1.21.газар эзэмших, ашиглах | Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч |
| 1.22.энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 1.23.тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 1.24.үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 1.25.элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 1.26.цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах | Тухайн аймаг, нийслэлийн байгаль орчны алба |
| 1.27.хоногт 50-100 шоометр ус ашиглах | Тухайн аймаг, нийслэлийн байгаль орчны алба |
| 1.28.хоногт 100 шоометрээс их ус ашиглах | Тухайн сав газрын захиргаа |
| 1.29.ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах | Тухайн ойн анги, эсхүл тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч |
| 1.30.ойгоос мод бэлтгэх эрх | Ойн анги, эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан |
| 1.31.газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

[/Энэ "1.14" дэх заалт ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ "1.11", "1.23" дахь заалт ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ "1.30, 1.31" дэх заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2.Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 2.1.банк байгуулах | Монголбанк |
| 2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх | Монголбанк |
| 2.3.зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх | Монголбанк |
| 2.4.систем ажиллуулах | Монголбанк |
| 2.5.төлбөрийн үйлчилгээ үзүүлэх | Монголбанк |
| 2.6.андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.7.банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.8.банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.9.банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |

| | |
|--|-----------------------------|
| 2.10.банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.11.банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.12.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.13.даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.14.даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.15.даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.16.ердийн, урт хугацааны, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.17.кастодианы үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.18.санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.19.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.20.үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.21.үнэт цаасны арилжаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.22.үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.23.үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.24.үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.25.үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.26.үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.27.үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.28.үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.29.үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.30.хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.31.хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |

| | |
|--|-----------------------------|
| 2.32.хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.33.хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.34.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.35.хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.36.хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.37.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.38.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |

[/Энэ "2.37, 2.38" дахь заалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|--|
| 3.1.бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.2.бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.3.даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал, түүний түүхий эд болон шатамхай, химийн хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.4.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх | Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.5.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.6.газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох | Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.7.газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох | Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.8.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах | Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.9.бохир усны гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.10.бохир ус цуглуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |

| | |
|--|--|
| 3.11.бохир ус татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.12.бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.13.бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.14.зөөврийн ус хангамжийн үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.15.орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.16.ус дамжуулах төвийн ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.17.ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.18.ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.19.хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.20.хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.21.цэвэр ус дамжуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |
| 3.22.цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөл |

4.Батлан хамгаалахын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 4.1.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэгслэлийг экспортлох, импортлох | Засгийн газар |
| 4.2.тогтоосон агаарын хаалганаас гадуур нэвтрэх агаарын хөлөгт зөвшөөрөл олгох | Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага |
| 4.3.хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх | Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, өөхүл Хил хамгаалах ерөнхий газар |

[/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

5.Зам, тээврийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 5.1.төмөр замын суурь бүтэц барих | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.2.авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх | Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.3.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх | Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.4.суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.5.тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх | Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.6.төмөр замын суурь бүтэц ашиглах | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.7.төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх | Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.8.усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх | Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.9.иргэний агаарын хөлгийн засвар, үйлчилгээ эрхлэх | Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 5.10.иргэний агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх | Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 5.11.иргэний нисэхэд ашиглах аэродром, нисэх буудлын үйлчилгээ эрхлэх | Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |

[/Энэ "5.7" заалтын "тээвэрлэлтийн" гэснийг "тээвэрлэгчийн" гэж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ "5.1" заалтын "Засгийн газар" гэснийг "Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

6.Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|--|
| 6.1.аудитын үйл ажиллагаа эрхлэх | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.2.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.3.үнэт цаас үйлдвэрлэх | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.4.хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.5.эд мөнгөний хонжворт сугалаа гаргах | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |

| | |
|---|--|
| 6.6.татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх | Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 6.7.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх | Гаалийн удирдах төв байгууллага |
| 6.8.гаалийн баталгаат барилгын талбай ажиллуулах | Гаалийн удирдах төв байгууллага |
| 6.9.гаалийн баталгаат үйлдвэрийн газар ажиллуулах | Гаалийн удирдах төв байгууллага |
| 6.10.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар ажиллуулах | Гаалийн удирдах төв байгууллага |
| 6.11.гаалийн тусгай бүс байгуулах | Гаалийн удирдах төв байгууллага |
| 6.12.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах | Гаалийн удирдах төв байгууллага |

7.Соёл, боловсролын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|--|
| 7.1.гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 7.2.их сургууль, дээд сургууль, коллежийн үйл ажиллагаа эрхлэх | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 7.3.олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 7.4.төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 7.5.музейн үйл ажиллагаа эрхлэх | Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 7.6.цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 7.7.ерөнхий боловсролын сургууль байгуулах | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 7.8.хүүхэд харах үйлчилгээ эрхлэх | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 7.9.гадаадын хуулийн этгээд Монгол Улсад боловсролын байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх | Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл |
| 7.10.их сургууль, дээд сургуулийн харьяа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага байгуулах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 7.11.гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага байгуулах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 7.12.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

[/Энэ "7.3" дахь заал т ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ "7.10, 7.11, 7.12" дахь заал т ыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 8.1.газрын тос борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих | Засгийн газар |

| | |
|--|---|
| 8.2.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх | Засгийн газар |
| 8.3.хүн амын эрүүл мэнд, мал, ан амьтан, байгаль орчинд онцгой нөлөө бүхий хортой бодисыг хамгаалан булахад зориулан газрын хэвлийг ашиглуулах | Засгийн газар |
| 8.4.бүх төрлийн шатахууны бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэх | Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.5.бүх төрлийн шатахууныг импортлох | Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.6.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх | Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.7.газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, ашиглах | Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.8.пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах | Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.9.үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил явуулах | Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.10.үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх | Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.11.төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх | Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.12.үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх | Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.13.байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тосны хураагуурын орон зайд газрын тос хадгалах | Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 8.14.ашигт малтмал ашиглах | Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 8.15.ашигт малтмал хайх | Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 8.16.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах | Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 8.17.цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх | Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 8.18.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах | Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 8.19.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх | Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 8.20.цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, импортлох, экспортлох | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

| | |
|--|--|
| 8.21.цацрагийн үүсгүүрийг угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.22.цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.23.цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.24.цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах | Цөмийн энергийн комисс |
| 8.25.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлах | Цөмийн энергийн комисс |
| 8.26.цөмийн төхөөрөмж ашиглах | Цөмийн энергийн комисс |
| 8.27.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах | Цөмийн энергийн комисс |
| 8.28.ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглуулах | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 8.29.түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 8.30.түгээмэл тархацтай ашигт малтмал хайх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |

[/Энэ "8.20", "8.21, 8.22, 8.23" дахь заалт ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|--|
| 9.1.тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх | Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 9.2.арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.3.мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.4.харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.5.олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.6.олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.7.өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.8.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.9.радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.10.сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |

| | |
|--|------------------------------------|
| 9.11.харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.12.харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.13.дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.14.төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |
| 9.15.улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх | Харилцаа холбооны зохицуулах хороо |

10.Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|--|
| 10.1.Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх | Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

11.Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|---|
| 11.1.иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, худалдах | Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 11.2.сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх | Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 11.3.тамга, тэмдэг үйлдвэрлэх | Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 11.4.төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх | Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 11.5.иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдах төв нээх, салбар нээх | Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 11.6.харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх | Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 11.7.архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх | Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 11.8.гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх | Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 11.9.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх | Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 11.10.галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх | Цагдаагийн төв байгууллага |
| 11.11.хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх | Цагдаагийн төв байгууллага |

| | |
|--|--|
| 11.12.нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулах | Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 11.13.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх | Хуульчдын холбоо |

12.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 12.1.уламжлалт технологиор үйлдвэрлэснээс бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх | Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 12.2.тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих | Засгийн газар |
| 12.3.тамхи импортлох | Засгийн газар |
| 12.4.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх | Засгийн газар |
| 12.5.согтууруулах ундаа импортлох | Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 12.6.ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 12.7.шинжлэх ухааны дэвшилтэт аргаар малын үүлдэр, омог шинээр бий болгох | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 12.8.бичил биетнийг өсгөвөрлөх, өндгөн эс, хөврөл, үрийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 12.9.гадаадаас сайжруулагч мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн авах | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 12.10.мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргах | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 12.11.таримал ургамлын үр үйлдвэрлэх | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 12.12.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох | Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 12.13.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч |
| 12.14.уламжлалт технологиор согтууруулах ундаа үйлдвэрлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |

[/Энэ хэсгийн "12.4-12.13" гэсэн дугаарлалтыг "12.5-12.14" гэж 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ "12.1, 12.4" дэх заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

13.Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|--|
| 13.1.сувилах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 13.2.сэргээн засах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 13.3.эм барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 13.4.эмчлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 13.5.эх барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 13.6.мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 13.7.эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 13.8.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |

| | |
|--|--|
| 13.9.сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.10.сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.11.түргэн тусламжийн үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.12.эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.13.эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.14.эх барихын тусламж, үйлчилгээ эрхлэх | Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.15.ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх | Эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.16.биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх | Эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 13.17.мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, худалдах | Эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 13.18.хүний эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх | Эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 13.19.хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх | Тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 13.20.өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхлэх | Тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар |

[/Энэ "13.16" дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

14.Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Тусгай зөвшөөрөл | Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 14.1. 0.1-5МВт-ын эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.2. 0.1-100МВт-ын эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.3. 100МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

| | |
|--|---|
| 14.4. 0.4-15кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.5. 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.6. 0.4-110кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.7. 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.8. 0.07-1.6 МПа даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.9. 0.07-4.0 МПа даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.10. 0.07-8.0 МПа даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.11. 8.0 МПа-аас дээш даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.12. 0.07-1.6 МПа даралттай даралтат савны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.13. 0.07-4.0 МПа даралттай даралтат савны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.14. 0.07-8.0 МПа даралттай даралтат савны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.15. 8.0 МПа-аас дээш даралттай даралтат савны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.16. 0.07-1.6 МПа даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

| | |
|---|---|
| 14.17. 0.07-4.0 МПа даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.18. 0.07-8.0 МПа даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.19. 8.0 МПа-аас дээш даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.20. 4.0 МПа-аас доош кгх/см ² даралтад ажилладаг тоноглолын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.21. 4.0 МПа-аас дээш кгх/см ² даралтад ажилладаг тоноглолын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.22.эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах | Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 14.23.цахилгаан үйлдвэрлэх | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.24.цахилгаан дамжуулах | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.25.цахилгаан түгээх | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.26.дулаан үйлдвэрлэх | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |

| | |
|---|---|
| 14.27.дулаан дамжуулах | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.28.дулаан түгээх | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.29.диспетчерийн зохицуулалт хийх | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.30.цахилгаан импортлох, экспортлох | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.31.эрчим хүчний барилга байгууламж барих | Улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих бол төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр Зохицуулах хороо |
| 14.32.эрчим хүчээр зохицуулалттай хангах | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.33.эрчим хүчээр зохицуулалтгүй хангах | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |
| 14.34.хийгээр хангах | Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл |

8.2 дугаар зүйл.Энгийн зөвшөөрлийн жагсаалт

1.Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| | |
|------------------|---|
| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|------------------|---|

| | |
|---|---|
| 1.1.амьтны цуглуулгыг гадаадад гаргах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.2.гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны сан бүхий газарт ус, усан орчинтой холбоотой шинжилгээ судалгаа явуулах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.3.харь ургамлыг байгальд тарималжуулах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.4.нэн ховор, ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.5.нэн ховор амьтныг эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнах, барих | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.6.тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.7.эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор амьтныг агнах, барих | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 1.8.байгалийн ойгоос зулзаган модыг шилжүүлэн суулгах | Тухайн аймаг, нийслэлийн Байгаль орчны газар |
| 1.9.газар эзэмших, ашиглах | Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч |
| 1.10.агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 1.11.амьтныг эзэмших, ашиглах | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 1.12.ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 1.13.ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглах | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 1.14.хоногт 50 шоомтрээс бага ус ашиглах | Тухайн сум, дүүргийн Засаг дарга |
| 1.15.хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч хуулийн этгээд ус ашиглах | Тухайн сав газрын захиргаа |
| 1.16.генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

[/Энэ "1.16" дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2.Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|---|
| 2.1.аутсорсингийн үйлчилгээ авах | Монгол банк |
| 2.2.банк, түүний салбар байгуулах, гадаад улсад банк, банкны салбар байгуулах | Монгол банк |
| 2.3.банк шинээр хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах | Монголбанк |

| | |
|---|-------------|
| 2.4.банкийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах | Монголбанк |
| 2.5.банкн дахь үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах | Монголбанк |
| 2.6.банк шинээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц өөрчлөгдөх, аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох | Монголбанк |
| 2.7.банкны нэр, байршлыг өөрчлөх | Монголбанк |
| 2.8.банкны үйл ажиллагаа эрхлэх, төлбөрийн үйлчилгээ, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хамаарал бүхий үйл ажиллагаа | Монголбанк |
| 2.9.банк гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах | Монголбанк |
| 2.10.банк гадаад төлбөр тооцоо хийх | Монголбанк |
| 2.11.гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх | Монголбанк |
| 2.12.банк зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах | Монголбанк |
| 2.13.зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах | Монгол банк |
| 2.14.банк зээлийн үйл ажиллагаа эрхлэх | Монголбанк |
| 2.15.мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх | Монголбанк |
| 2.16.банк мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх | Монголбанк |
| 2.17.мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх | Монголбанк |
| 2.18.төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх | Монголбанк |
| 2.19.банк төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх | Монголбанк |
| 2.20.төлбөрийн хэрэгсэл гаргах, хүлээн авах | Монголбанк |
| 2.21.банк үнэт зүйл хадгалах | Монголбанк |
| 2.22.банк үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах | Монгол банк |
| 2.23.банк өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах | Монголбанк |
| 2.24.банк санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх | Монголбанк |
| 2.25.цахим мөнгө гаргах | Монголбанк |

| | |
|---|-----------------------------|
| 2.26.албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.27.албан журмын даатгагчдын холбооны дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.28.банк бус санхүүгийн салбар, төлөөлөгчийн газар, нэгж нээх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.29.банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.30.банк бус санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.31.банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.32.банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.33.банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.34.банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.35.банк бус санхүүгийн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.36.гадаадын даатгагч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.37.гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.38.даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.39.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.40.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдийн үйл ажиллагаатай нэгтгэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.41.даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа нээх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.42.даатгалын байгууллагын нэр, байршлыг өөрчлөх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.43.даатгалын байгууллагын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах | Санхүүгийн зохицуулах хороо |

| | |
|---|-----------------------------|
| 2.44.даатгалын байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.45.нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.46.тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.47.үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.48.үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт оруулах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.49.үнэт цаасны хоёрдогч зах зээлд үнэт цаасыг арилжих | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.50.үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах | Санхүүгийн зохицуулах хороо |
| 2.51.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх | Санхүүгийн зохицуулах хороо |

3.Барилга, хот байгуулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 3.1.цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой, газрын тосны боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой зэрэг улсын чанартай барилга байгууламжид барилгын ажлын зөвшөөрөл олгох | Засгийн газар |
| 3.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг хэвлэх | Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх | Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга |

4.Зам, тээврийн хөгжлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|--|
| 4.1.барилга байгууламж барих, өргөтгөх, шугам сүлжээнд холболт хийх зэрэг зайлшгүй шаардлагаар төрийн өмчийн авто замыг сэтлэх, орц, гарц гаргах | Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 4.2.олон улсын нислэг үйлдэх | Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 4.3.Монгол Улсын иргэний нисэхийн зориулалтаар ашиглаж буй агаарын зай болон агаарын замд буудлага, дэлбэлэлт хийх, пуужин харвах зэргээр нислэгт аюул учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулах | Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |

| | |
|--|---|
| 4.4.тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох | Цагдаагийн төв байгууллага |
| 4.5.авто зам, замын байгууламжаар зайлшгүй тохиолдолд даац хэтэрсэн, зөвшөөрөгдсөнөөс илүү овор хэмжээтэй буюу тусгай хамгаалалтгүйгээр гинжит дугуйтай тээврийн хэрэгслээр зорчих | Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, хамгаалалтыг хариуцсан байгууллага |

5.Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|---|
| 5.1.гадаадын төрийн өмчит хуулийн этгээд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших | Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.2.гадаадын төрийн өмчит хуулийн этгээд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх | Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 5.3.гаалийн түр агуулах ажиллуулах | Гаалийн удирдах төв байгууллага |
| 5.4.үнэлгээчний эрх олгох | Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага |

[/Энэ "5.2" дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

[/Энэ "5.1" дэх заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

6.Соёл, боловсролын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|--|
| 6.1.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор улсын хилээр нэвтрүүлэх | Засгийн газар |
| 6.2.дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 6.3.Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хамтарсан сургууль байгуулах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 6.4.их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль байгуулах | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 6.5.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 6.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх | Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт соёлын биет бус өвийн судалгаа хийх | Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.8.нийтийн өмчийн соёлын биет өвийг хувиан олшруулах | Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.9.соёлын биет өвийг сэргээн засварлах | Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |
| 6.10.соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх | Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 6.11.соёлын биет өвийг зөөж тээвэрлэх | Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

| | |
|---|--|
| 6.12.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх, сэргээн засварлах, гадаад улсад үзэсгэлэнд гаргах зорилгоор улсын хилээр нэвтрүүлэх | Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 6.13.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, хуулийн этгээд кино зураг авалт хийх | Кино урлагийн зөвлөл |
| 6.14.Мэргэжлийн болон техникийн боловсролын шинэ мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

[/Энэ "6.12" дахь заалт ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ "6.1" дэх заалт ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ "6.14" дахь заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|---|
| 7.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх | Цагдаагийн төв байгууллага |
| 7.2.хуулийн этгээд нь хэрэгцээнээс илүүдэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдан авах, эрх бүхий байгууллагад худалдах | Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |

[/Энэ "7.2" дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

8.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|--|
| 8.1.мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх | Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.2.кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх | Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 8.3.радио давтамжийг нийтийн үйлчилгээний бус зориулалтаар ашиглах | Харилцаа холбооны зохицуулах хороо |

[/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

9.Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 9.1.гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхээр урих | Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 9.2.гадаад ажилтан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх | Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |

10.Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|--|---|
| 10.1.гадаадын иргэн улсын онц чухал объектод ажиллах | Засгийн газар |
| 10.2.төрийн архивын сан хөмрөгийн баримтыг гадаадад түр гаргах | Засгийн газар |
| 10.3.нотариатын үйл ажиллагаа эрхлэх | Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн |

| | |
|---|---|
| 10.4.улсын хилийн зурваст нэвтэрч ажил, үйлдвэрлэл явуулах | Улсын хил хамгаалах байгууллага |
| 10.5.хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суудаггүй иргэн, байрладаггүй аж ахуйн нэгж, байгууллага нь улсын хилийн бүсэд нэвтэрч ажил, үйлдвэрлэл явуулах | Улсын хил хамгаалах байгууллага |
| 10.6.давамгайл байдлаар хуулийн этгээд бусад этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-иос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй нэгдэх, нийлэх | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар |
| 10.7.зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлт хийх | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар |
| 10.8.ан агнах зорилгоор галт зэвсэг улсын хилээр оруулах, гаргах | Цагдаагийн төв байгууллага |
| 10.9.галт зэвсгийн гэрчилгээ олгох | Цагдаагийн төв байгууллага |
| 10.10.галт зэвсэг худалдан авах | Цагдаагийн төв байгууллага |
| 10.11.хот, суурин газрын авто замын зурвас газарт худалдаа, үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай ашиглах | Тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга |
| 10.12.шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх | Шүүх шинжилгээний төв байгууллага |
| 10.13.нийтийн эзэмшил гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай ашиглах | Тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга |
| 10.14.тогтоосон агаарын хаалганаас гадуур нэвтрэх агаарын хөлөгт зөвшөөрөл олгох | Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага |
| 10.15.хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх | Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, эсхүл Хил хамгаалах ерөнхий газар |

[/Энэ "10.12" дахь заалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ "10.6" дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

[/Энэ "10.11" дэх заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ "10.13, 10.14, 10.15" дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|---|---|
| 11.1.стратегийн хүнсийг экспортлох, импортлох | Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 11.2.малыг гадаадад гаргахад төрөл, зүйл тус бүрд нэг удаагийн зөвшөөрөл олгох | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 11.3.судалгаа, шинжилгээний зорилгоор мал үржүүлгийн бүтээгдэхүүнийг гадаадад гаргахад ижил зүйлийн тав хүртэл сорьцод нэг удаагийн зөвшөөрөл олгох | Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 11.4.мал, амьтны тэжээлийн нэмэлт, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох | Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 11.5.олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгох | Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 11.6.тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх | Тухайн сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч |

12.Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:

| Энгийн зөвшөөрөл | Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд |
|----------------------------------|--|
| 12.1.эмийн зар сурталчилгаа хийх | Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |

[/Энэ "12.1" дэх заалт ад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

9.1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээд, түүний чиг үүрэг

- 1.Эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.
- 2.Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар гүйцэтгэнэ.
- 3.Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 11 гишүүнээс бүрдэх бөгөөд Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ.
- 4.Зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх, тэдгээрийн ажиллах журмыг Засгийн газар батална.
- 5.Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 5.1.эрх бүхий этгээдийг арга зүйн удирдлагаар хангах;
 - 5.2.зөвшөөрөл олгож байгаа байдал, түүний үр нөлөөний талаар хяналт шинжилгээ, үнэлгээг хийх, санал, дүгнэлт гаргах;
 - 5.3.энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргах;
 - 5.4.эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгож байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;
 - 5.5.зөвшөөрлийн хууль тогтоомж зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах.
- 6.Энэ хуулийн хэрэгжилт болон зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагаанд холбогдох санал, зөвлөмжийг гаргуулах зорилгоор тусгай мэдлэг, мэргэшил шаардагдах асуудлаар туслалцаа үзүүлэх шинжээч, мэргэжилтнийг татан оролцуулж болно.

9.2 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

- 1.Зөвлөл зөвшөөрөл, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь энэ хуулийн зорилго, зарчим, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэхэд энэ хуулийн 9.3 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ, үнэлгээг гурван жил тутам хийнэ.
- 2.Зөвлөл энэ зүйлийн 1-д заасны дагуу хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн тухайн зөвшөөрлийг хэвээр үлдээх, эсхүл зөвшөөрлийг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, эсхүл зөвшөөрлийн жагсаалтаас хасах, өөрчлөх асуудлаар хуулийн төсөл боловсруулах эсэх талаар дүгнэлт гаргана.

9.3 дугаар зүйл.Зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчлөхөд дүгнэлт гаргах

- 1.Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаар дүгнэлт гаргахдаа энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 14-т заасан зарчмыг баримтална.
- 2.Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаарх дүгнэлтийг дараах шалгуур үзүүлэлтээр гаргана:
 - 2.1.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хамгаалахад тухайн шинээр бий болгох зөвшөөрөл шаардлагатай эсэх;
 - 2.2.энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн жагсаалттай давхардах, уялдах эсэх;
 - 2.3.зөвшөөрлийн ангилалд үндэслэн тухайн зөвшөөрлийн хэрэгцээ, шаардлага, эрсдэлийн түвшин, үнэлгээтэй уялдах эсэх;
 - 2.4.эдийн засаг, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөлөл;
 - 2.5.тухайн шинээр бий болгох зөвшөөрөлтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас гарах зардал;
 - 2.6.хууль санаачлагчаас Нийтийн сонсголын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн сонгол явуулсан эсэх.
- 3.Энэ зүйлийн 2-т заасан дүгнэлтийг энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5.3-т заасан санал, дүгнэлтийн хамт Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

9.4 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон гомдол гаргах

- 1.Иргэн, хуулийн этгээд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой гомдлыг Захиргааны ерөнхий хуулийн 93 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргана.

9.5 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.6 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

- 1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, эсхүл хуулийн төслийг хэлэлцэн батлах үе шатанд байгаа зөвшөөрөлтэй холбоотой хуулийн төсөлд энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5.3 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт хамаарахгүй.

9.7 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

- 1.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР